ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ЗАА-2026/152/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2026 он


Төрийн Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсувд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: tuul9565@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан....13
4.1 Ерөнхий зүйл ....13
4.2 Материаллаг байдал ....14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16
5. Аудитын илрүүлэлт ....16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-3612
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2026.02.16 № 158

танай ______ -ны № ______ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА
Т.ПҮРЭВДОРЖ-д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Ажлын цаг ашиглалтын бүртгэл", "Ажлын цагийн тооцоо"-ны маягтыг хөтөлж ажилласан цагийг баталгаажуулаагүй, ээлжийн ажлыг нотлох баримтгүй, албан хаагчдад ажилласан хоног зөрүүтэй, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон, мөн листийн хугацаа болон цалинтай чөлөө олгохдоо нэмэгдэл хөлсийг бүтэн олгосон, Засгийн газраас тогтоосон байгууллагын даргын албан тушаалын үндсэн цалинг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй, төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 186.2 сая төгрөгийн өр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

D:\Албан бичиг\A4-2026.docx

812605355

Тус байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын сангаас 5,267.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 6.4 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан томилолтын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй 3.9 сая төгрөгийн томилолт олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 116.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 88.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| дд | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 537,288,311.92 | 302,617,739.34 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 625,960.96 | 3,491,880.04 |
| 8 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 625,960.96 | 3,491,880.04 |
| 9 | Төгрөг | 625,960.96 | 3,491,880.04 |
| 10 | Төрийн сангийн харилцах | 625,960.96 | 3,491,880.04 |
| 27 | АВЛАГА | 249,775,014.22 | 32,123,509.04 |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 116,500.00 | 4,416,263.47 |
| 29 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 6,216,565.00 | 6,216,565.00 |
| 30 | Татаас санхүүжилтийн авлага | 228,441,949.22 | 6,490,680.57 |
| 34 | Бусад авлага | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 35 | Байгууллагаас авах авлага | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 286,887,336.74 | 267,002,350.26 |
| 61 | Түүхий эд материал | 193,541,357.30 | 142,529,630.82 |
| 62 | Тусгай зориулалттай материал | 10,259,525.00 | 15,050,625.00 |
| 63 | Эм боох материал | 183,281,832.30 | 127,479,005.82 |
| 66 | Хангамжийн материал | 93,345,979.44 | 124,472,719.44 |
| 67 | Бичиг хэргийн материал | - | 120,000.00 |
| 68 | Аж ахуйн материал | 29,765,279.44 | 39,064,919.44 |
| 69 | Сэлбэг хэрэгсэл | 8,700,000.00 | 28,868,300.00 |
| 71 | Барилгын засварын материал | 40,838,000.00 | 45,044,000.00 |
| 72 | Хүнсний материал | 5,046,200.00 | 2,379,000.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 8,996,500.00 | 8,996,500.00 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,188,334,932.15 | 2,958,939,622.50 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,188,334,932.15 | 2,958,939,622.50 |
| 108 | Биет хөрөнгө | 3,097,579,932.15 | 2,868,297,122.50 |
| 109 | Барилга, байгууламж | 1,423,107,900.00 | 1,423,107,900.00 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | (139,035,240.54) | (167,282,905.62) |
| 111 | Авто тээврийн хэрэгсэл | 420,000,000.00 | 420,000,000.00 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | (51,910,118.97) | (100,474,404.69) |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 2,290,985,249.07 | 2,305,567,161.62 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (919,076,203.96) | (1,079,536,874.42) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 162,726,900.00 | 191,726,900.00 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (89,218,553.45) | (124,810,654.39) |
| 126 | Биет бус хөрөнгө | 90,755,000.00 | 90,642,500.00 |
| 127 | Програм хангамж | 515,000.00 | 515,000.00 |
| 128 | Хасагдуулга | (290,000.00) | (402,500.00) |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 90,530,000.00 | 90,530,000.00 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 3,725,623,244.07 | 3,261,557,361.84 |

| | | | |
|---|---|---|---|
| 164 | Өглөг | 158,576,889.89 | 186,202,765.90 |
| 165 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | (0.00) | 35,457,690.90 |
| 166 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 3,896,630.00 |
| 170 | Бусад өглөг | 158,576,889.89 | 146,848,445.00 |
| 171 | Байгууллагад төлөх өглөг | 158,576,889.89 | 146,492,645.00 |
| 172 | Хувь хүмүст төлөх өглөг | - | 355,800.00 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 3,567,046,354.18 | 3,075,354,595.94 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 3,567,046,354.18 | 3,075,354,595.94 |
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 1,231,388,510.62 | 1,231,388,510.62 |
| 217 | Өмч: -Төрийн өмч | 1,231,388,510.62 | 1,231,388,510.62 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 1,777,211,268.38 | 1,285,519,510.14 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 1,777,211,268.38 | 1,777,211,268.38 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | - | (491,691,758.24) |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 558,446,575.18 | 558,446,575.18 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 3,725,623,244.07 | 3,261,557,361.84 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| ДД | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 6,003,457,404.34 | 6,288,023,214.40 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 658,055,646.34 | 192,565,267.40 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 658,055,646.34 | 192,565,267.40 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 65,594,230.00 | 83,494,077.65 |
| 82 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 64,994,230.00 | 77,593,273.00 |
| 83 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | - |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 5,900,804.65 |
| 94 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | 555,689,792.94 | 105,385,299.75 |
| 95 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | 36,771,623.40 | 3,685,890.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,345,401,758.00 | 6,095,457,947.00 |
| 122 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 367,858,484.00 |
| 126 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | - | 367,858,484.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 424,444,900.00 | 453,933,500.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 424,444,900.00 | 453,933,500.00 |
| 143 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 4,920,956,858.00 | 5,273,665,963.00 |
| 145 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 4,920,956,858.00 | 5,273,665,963.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 5,461,594,704.48 | 6,779,714,972.64 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,461,594,704.48 | 6,779,714,972.64 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,398,745,485.67 | 6,411,870,388.31 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 3,196,099,554.00 | 3,959,140,298.31 |
| 151 | Цалин | 1,587,440,518.00 | 1,823,359,882.22 |
| 152 | Нэмэгдэл цалин | 1,400,054,714.00 | 1,886,109,492.09 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 56,463,000.00 | 114,658,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 154 | Урамшуулал | 152,141,322.00 | 135,012,924.00 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 417,759,707.16 | 507,345,353.26 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 282,110,380.03 | 337,287,064.72 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 32,740,109.22 | 40,737,220.93 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 23,163,963.14 | 32,002,372.28 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 16,947,514.12 | 19,407,616.62 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 62,797,740.65 | 77,911,078.71 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 368,595,681.19 | 451,992,615.21 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 36,440,196.59 | 45,291,575.21 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 280,293,125.00 | 291,093,440.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 51,862,359.60 | 105,607,600.00 |
| 168 | Байрны түрээс | - | 10,000,000.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 170,884,209.00 | 151,826,376.00 |
| 171 | Бичиг хэргийн материал | 21,398,200.00 | 18,508,150.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 86,766,633.00 | 81,333,965.00 |
| 173 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 5,332,869.40 | 4,872,531.00 |
| 175 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 5,115,000.00 | 10,394,000.00 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 52,271,506.60 | 36,717,730.00 |
| 181 | Нормативт зардал | 695,733,657.86 | 763,163,439.13 |
| 182 | Эм | 599,756,507.86 | 646,738,989.13 |
| 183 | Хоол | 95,977,150.00 | 116,424,450.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 71,800,410.00 | 33,264,990.00 |
| 189 | Урсгал засвар | 71,800,410.00 | 33,264,990.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 36,328,200.00 | 28,907,400.00 |
| 192 | Дотоод томилолтын зардал | 36,328,200.00 | 28,907,400.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 47,936,490.00 | 59,357,502.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 42,332,000.00 | 55,281,040.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,500,000.00 | 1,612,800.00 |
| 197 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 1,799,100.00 | 1,800,000.00 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 605,727.00 | 272,742.00 |
| 199 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | 99,000.00 | 132,000.00 |
| 201 | Газрын төлбөр | 192,000.00 | 169,920.00 |
| 202 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 714,400.00 | - |
| 203 | Улсын мэдээллийн маягтын зардал | 694,263.00 | 89,000.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 393,607,576.46 | 456,872,414.40 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,034,500.00 | 5,918,700.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 379,573,076.46 | 450,953,714.40 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 62,849,218.81 | 367,844,584.33 |
| 228 | Бусад урсгал шилжүүлэг | 7,000,000.00 | 367,844,584.33 |
| 234 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 161,348,584.33 |
| 235 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 206,496,000.00 |
| 236 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 7,000,000.00 | - |
| 242 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 55,849,218.81 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 245 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,849,218.81 | - |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 541,862,699.86 | (491,691,758.24) |
| 276 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 3,121,906.68 | - |
| 277 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,121,906.68 | - |
| 287 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | (3,121,906.68) | - |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 538,740,793.18 | (491,691,758.24) |

## 2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| дд | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 5,207,287,363.78 | 6,166,560,539.43 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 80,594,230.00 | 77,593,273.00 |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | 80,594,230.00 | 77,593,273.00 |
| 82 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 80,594,230.00 | 77,593,273.00 |
| 83 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 79,994,230.00 | 77,593,273.00 |
| 84 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | - |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,126,693,133.78 | 6,088,967,266.43 |
| 121 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 367,858,484.00 |
| 125 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | - | 367,858,484.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 424,444,900.00 | 453,933,500.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 424,444,900.00 | 453,933,500.00 |
| 143 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 4,702,248,233.78 | 5,267,175,282.43 |
| 145 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,702,248,233.78 | 5,267,175,282.43 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 5,077,864,939.58 | 6,280,013,464.57 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,077,864,939.58 | 6,280,013,464.57 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,015,015,720.77 | 5,912,168,880.24 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 3,196,099,554.00 | 3,978,904,272.00 |
| 151 | Үндсэн цалин | 1,591,314,770.00 | 1,875,385,402.02 |
| 152 | Нэмэгдэл | 1,397,159,807.00 | 1,852,534,556.69 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 56,494,650.00 | 112,574,958.21 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 151,130,327.00 | 138,409,355.08 |
| 157 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 417,859,707.16 | 456,423,452.14 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 283,617,719.03 | 303,822,347.76 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 32,740,109.22 | 36,336,043.87 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 23,163,963.11 | 26,427,948.03 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 15,540,175.15 | 17,960,986.91 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 62,797,740.65 | 71,876,125.57 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 403,217,961.19 | 448,135,985.21 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 36,440,196.59 | 45,291,575.21 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 312,242,405.00 | 291,093,440.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 54,535,359.60 | 101,750,970.00 |
| 168 | Байрны түрээс | - | 10,000,000.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 185,125,552.40 | 154,796,516.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 171 | Бичиг хэрэг | 22,441,200.00 | 18,628,150.00 |
| 172 | Тээвэр, шатахуун | 93,266,633.00 | 77,499,985.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,332,869.40 | 4,872,531.00 |
| 175 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,115,000.00 | 10,169,000.00 |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 58,969,850.00 | 43,626,850.00 |
| 181 | Нормативт зардал | 582,240,946.02 | 714,911,262.89 |
| 182 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 474,141,846.02 | 611,342,362.89 |
| 183 | Хоол, хүнс | 99,999,100.00 | 103,568,900.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,100,000.00 | - |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 128,924,210.00 | 64,853,790.00 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | - | 19,900,000.00 |
| 188 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | 6,022,800.00 | 400,000.00 |
| 189 | Урсгал засвар | 122,901,410.00 | 44,553,790.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 37,576,800.00 | 28,867,400.00 |
| 192 | Дотоод албан томилолт | 37,576,800.00 | 28,867,400.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 49,936,490.00 | 59,357,502.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 44,332,000.00 | 55,281,040.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,500,000.00 | 1,612,800.00 |
| 197 | Даатгалын үйлчилгээ | 1,799,100.00 | 1,800,000.00 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 605,727.00 | 272,742.00 |
| 199 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 132,000.00 |
| 201 | Газрын төлбөр | 192,000.00 | 169,920.00 |
| 202 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 714,400.00 | - |
| 203 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 694,263.00 | 89,000.00 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,034,500.00 | 5,918,700.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,034,500.00 | 5,918,700.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 62,849,218.81 | 367,844,584.33 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 7,000,000.00 | 367,844,584.33 |
| 231 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 161,348,584.33 |
| 232 | Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 206,496,000.00 |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 7,000,000.00 | - |
| 239 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 55,849,218.81 | - |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,849,218.81 | - |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 129,422,424.20 | (113,452,925.14) |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 128,838,150.00 | 112,123,105.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 128,838,150.00 | 112,123,105.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 128,838,150.00 | 112,123,105.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 128,838,150.00 | 112,123,105.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (128,838,150.00) | (112,123,105.00) |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 584,274.20 | (225,576,030.14) |

| | | | |
|---|---|---|---|
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 41,686.76 | 625,960.96 |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 625,960.96 | 3,491,880.04 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2024 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 1,224,463,510.62 | 558,446,575.18 | 798,535,361.64 | 2,581,445,447.44 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,224,463,510.62 | 558,446,575.18 | 798,535,361.64 | 2,581,445,447.44 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | 439,935,113.56 | 439,935,113.56 |
| 9 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,231,388,510.62 | 558,446,575.18 | 1,777,211,268.38 | 3,567,046,354.18 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,231,388,510.62 | 558,446,575.18 | 1,777,211,268.38 | 3,567,046,354.18 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,231,388,510.62 | 558,446,575.18 | 1,777,211,268.38 | 3,567,046,354.18 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | (491,691,758.24) | (491,691,758.24) |
| 18 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,231,388,510.62 | 558,446,575.18 | 1,285,519,510.14 | 3,075,354,595.94 |

## 2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| дд | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 625,960.96 | (625,960.96) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,575,601,660.00 | 6,392,136,569.57 | 183,465,090.43 | 97.21 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 6,575,601,660.00 | 6,392,136,569.57 | 183,465,090.43 | 97.21 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 6,252,589,460.00 | 6,024,291,985.24 | 228,297,474.76 | 96.35 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,288,384,500.00 | 3,978,904,272.00 | 309,480,228.00 | 92.78 |
| 6 | Үндсэн цалин | 2,258,898,000.00 | 1,875,385,402.02 | 383,512,597.98 | 83.02 |
| 7 | Нэмэгдэл | 1,701,230,200.00 | 1,852,534,556.69 | (151,304,356.69) | 108.89 |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олговор | 95,195,000.00 | 112,574,958.21 | (17,379,958.21) | 118.26 |
| 9 | Урамшуулал | 233,061,300.00 | 138,409,355.08 | 94,651,944.92 | 59.39 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 536,048,000.00 | 456,423,452.14 | 79,624,547.86 | 85.15 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 364,512,700.00 | 303,822,347.76 | 60,690,352.24 | 83.35 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 42,883,800.00 | 36,336,043.87 | 6,547,756.13 | 84.73 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 21,441,900.00 | 26,427,948.03 | (4,986,048.03) | 123.25 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 21,441,900.00 | 17,960,986.91 | 3,480,913.09 | 83.77 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 85,767,700.00 | 71,876,125.57 | 13,891,574.43 | 83.80 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 448,034,660.00 | 448,135,985.21 | (101,325.21) | 100.02 |
| 18 | Гэрэл цахилгаан | 45,290,400.00 | 45,291,575.21 | (1,175.21) | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 19 | Түлш, халаалт | 290,993,360.00 | 291,093,440.00 | (100,080.00) | 100.03 |
| 20 | Цэвэр, бохир ус | 101,750,900.00 | 101,750,970.00 | (70.00) | 100.00 |
| 21 | Байрны түрээс | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.00 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 154,033,400.00 | 154,796,516.00 | (763,116.00) | 100.50 |
| 23 | Бичиг хэрэг | 23,000,000.00 | 18,628,150.00 | 4,371,850.00 | 80.99 |
| 24 | Тээвэр (шатахуун) | 67,500,200.00 | 77,499,985.00 | (9,999,785.00) | 114.81 |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 5,700,100.00 | 4,872,531.00 | 827,569.00 | 85.48 |
| 27 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,750,000.00 | 10,169,000.00 | 1,581,000.00 | 86.54 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 46,083,100.00 | 43,626,850.00 | 2,456,250.00 | 94.67 |
| 30 | Нормативт зардал | 640,501,700.00 | 714,911,262.89 | (74,409,562.89) | 111.62 |
| 31 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 528,351,790.00 | 611,342,362.89 | (82,990,572.89) | 115.71 |
| 32 | Хоол, хүнс | 104,549,910.00 | 103,568,900.00 | 981,010.00 | 99.06 |
| 33 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 7,600,000.00 | - | 7,600,000.00 | - |
| 34 | Эд хогшил худалдан авах | 84,600,000.00 | 176,976,895.00 | (92,376,895.00) | 209.19 |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | 42,000,000.00 | 103,023,105.00 | (61,023,105.00) | 245.29 |
| 36 | Тавилга | - | 29,000,000.00 | (29,000,000.00) | - |
| 37 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 2,666,600.00 | 400,000.00 | 2,266,600.00 | 15.00 |
| 38 | Урсгал засвар | 39,933,400.00 | 44,553,790.00 | (4,620,390.00) | 111.57 |
| 39 | Томилолт, зочны зардал | 30,300,000.00 | 28,867,400.00 | 1,432,600.00 | 95.27 |
| 41 | Дотоод албан томилолт | 30,300,000.00 | 28,867,400.00 | 1,432,600.00 | 95.27 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 59,583,400.00 | 59,357,502.00 | 225,898.00 | 99.62 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 52,166,600.00 | 55,281,040.00 | (3,114,440.00) | 105.97 |
| 45 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,612,800.00 | 1,612,800.00 | - | 100.00 |
| 46 | Даатгалын үйлчилгээ | 1,800,000.00 | 1,800,000.00 | - | 100.00 |
| 47 | Тээврийн хэрэгслийн татвар | 680,000.00 | 272,742.00 | 407,258.00 | 40.11 |
| 48 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132,000.00 | 132,000.00 | - | 100.00 |
| 50 | Газрын төлбөр | 192,000.00 | 169,920.00 | 22,080.00 | 88.50 |
| 51 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,200,000.00 | - | 1,200,000.00 | - |
| 52 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,800,000.00 | 89,000.00 | 1,711,000.00 | 4.94 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,103,800.00 | 5,918,700.00 | 5,185,100.00 | 53.30 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,103,800.00 | 5,918,700.00 | 5,185,100.00 | 53.30 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 323,012,200.00 | 367,844,584.33 | (44,832,384.33) | 113.88 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 323,012,200.00 | 367,844,584.33 | (44,832,384.33) | 113.88 |
| 76 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 181,684,200.00 | 161,348,584.33 | 20,335,615.67 | 88.81 |
| 77 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 141,328,000.00 | 206,496,000.00 | (65,168,000.00) | 146.11 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 7,242,578,700.00 | 6,166,560,539.43 | 1,076,018,160.57 | 85.14 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 367,858,400.00 | - | 367,858,400.00 | - |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 367,858,400.00 | - | 367,858,400.00 | - |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 453,933,500.00 | 453,933,500.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 104 | Орон нутгийн төсвөөс | 453,933,500.00 | 453,933,500.00 | - | 100.00 |
| 106 | НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 5,916,236,600.00 | 5,267,175,282.43 | 649,061,317.57 | 89.03 |
| 108 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,916,236,600.00 | 5,267,175,282.43 | 649,061,317.57 | 89.03 |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 504,550,200.00 | 77,593,273.00 | 426,956,927.00 | 15.38 |
| 111 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 116,754,000.00 | 77,593,273.00 | 39,160,727.00 | 66.46 |
| 112 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 387,796,200.00 | - | 387,796,200.00 | - |
| 120 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 367,858,484.00 | (367,858,484.00) | - |
| 124 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 367,858,484.00 | (367,858,484.00) | - |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 625,960.96 | (625,960.96) | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 3,491,880.04 | (3,491,880.04) | - |

**2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31* *төгрөгөөр/*

| ДД | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|
| 1 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 453,933,500.00 |
| 2 | Орон нутгийн төсвөөс | 453,933,500.00 |
| 3 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **448,135,985.21** |
| 4 | Гэрэл цахилгаан | 45,291,575.21 |
| 5 | Түлш, халаалт | 291,093,440.00 |
| 6 | Цэвэр, бохир ус | 101,750,970.00 |
| 7 | Байрны түрээс | 10,000,000.00 |
| **8** | **Урсгал засвар** | **3,024,000.00** |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 2,264,791.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 181,909.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 6,665.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,076,215.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

**3.1 Залруулсан алдаа:** Данснаас хассан үндсэн хөрөнгийн бүртгэлийг буруу хийж, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртгийг сөрөг утгатай тайлагнасан 177,976.4 мянган төгрөгийн, санхүүгийн тайлангийн уялдаа зөрүүтэй илэрхийлсэн 3,933.5 мянган төгрөгийн алдаа байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Төлбөрийн акт**

Албан хаагчдад 6,665.8 мянган төгрөгийн цалин, нэмэгдэл болон илүү цагийн нэмэгдэл хөлс, үр дүнгийн урамшууллыг үндэслэлгүйгээр илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**3.3 Албан шаардлага**

- Албан томилолтыг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй 3,903.4 мянган төгрөгийн томилолт олгосон;

- Албан хаагчдын ажилласан цагийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Ажлын цаг ашиглалтын бүртгэл", "Ажлын цагийн тооцоо"-ны маягтаар баталгаажуулаагүй, ээлжийн ажлыг нотлох баримтгүйгээр 1,886,109.5 мянган төгрөгийн цалин тооцож олгосон;

- Засгийн газраас тогтоосон байгууллагын даргын албан тушаалын үндсэн цалинг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, албан хаагчдын цалин, нэмэгдлийг илүү тооцон олгож, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй, төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 186,202.7 мянган төгрөгийн өр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2-д Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3 дахь хэсгийн 1-д “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ.

**3.4 Зөвлөмж хүргүүлээгүй**

Нийт илрүүлсэн 2,082,881.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материллаг түвшнээс өндөр тул “Хязгаарлалттай” дүгнэлт хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэзс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Данснаас хассан үндсэн хөрөнгийн бүртгэлийг буруу хийж, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртгийг сөрөг утгатай тайлагнасан. | 1 | 177,976.5 | | | 1 | 177,976.5 | 1 | 177,976.5 | | | | |
| Санхүүгийн тайлангийн бариаг 3.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 3,933.5 | | | 1 | 3,933.5 | 1 | 3,933.5 | | | | |
| **Дүн** | **2** | **181,909.9** | | | **2** | **181,909.9** | **2** | **181,909.9** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ээлжийн ажлыг нотлох баримт байхгүй, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Ажлын цаг ашиглалтын бүртгэл", "Ажлын цагийн тооцоо"-ны маягтыг хөтлөж, ажилласан цагийг баталгаажуулаагүйгээр цалин хөлсийг олгосон. | 1 | 1,886,109.5 | | | 1 | 1,886,109.5 | | | | | |
| Цалин нэмэгдэл илүү цаг ажилласан хоног зөрүүтэй тооцож олгосон, листний хугацаанд бүтэн цалин олгосон цалинтай чөлөө олгохдоо нэмэгдэл хөлсийг бүтэн тооцож олгосон. | 1 | 6,344.9 | 1 | 6,344.9 | | | | | | | |
| 3 албан хаагчид үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон | 1 | 320.9 | 1 | 320.9 | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Албан томилолтын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, баримт бүрдэл дутуу 3.9 сая төгрөгийн томилолт олгосон байна. | 1 | 3,903.4 | | | 1 | 3,903.4 | | | | | |
| Засгийн газраас тогтоосон байгууллагын даргын албан тушаалын үндсэн цалинг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, албан хаагчдын цалин, нэмэгдлийг илүү тооцож олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасныг зөрчсөн байна. Мөн батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй, төсвийг зохистой удирдаагүй 2025 онд 186.2 сая төгрөгийн өглөгтэй ажиллаж, санхүүгийн тайланд өглөгийн дүн өндөр тусгагдсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна. 70.5 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. | | 186,202.7 | | | | 186,202.7 | | | | | |
| **Дүн** | **5** | **2,082,881.4** | **2** | **6,665.8** | **3** | **2,076,215.6** | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2026-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР ОГНОО: 2026-02-22

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2026-02-22

**БОЛОВСРУУЛСАН:**

СҮЛД АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2026-02-22